



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/494

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.7, 2.9 дэх заалт, Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах комиссын 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 10 дугаар тэмдэглэл, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл анх удаа олгох 2 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг нэгдүгээр, Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтанд тэнцсэн 1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



Эрдүүл мэддийн сайдын
2017 оны 12 сарын 08-ны өдрийн
1 дугаар тушаалтны 1 дугаар хавсралт

1/499

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖЛИТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний серий/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн лийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Санжей Сингх Negi Sanjay Singh Negi	Бугд Найрамдах ЭнэтхэгУлс	Цэргийн төв эмнэлэг	ГЭ0001852	Мэс засал судалал /хоол боловсруулах тогтолцооны мэс засал судалал/	Эмчлэх	2017.12.04 2017.12.07 /4 хоног/
2.	Панкаж Кумар Панде Pankaj Kumar Pande	Бугд Найрамдах Энэтхэг Улс	Цэргийн төв эмнэлэг	ГЭ0001853	Мэс засал судалал /Хавдрын мэс засал судалал/	Эмчлэх	2017.12.04 2017.12.07 /4 хоног/

ЭРҮҮЛ МЭНДИЙН сайдын
2017 оны 12 сарын 08 өдрийн
... дугаар тушаалтын 2 дугаар хавсралт

Ж/Ч99

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТАНД
ТЭНЦСЭН ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний серий/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Ян Жин Гуан Yang Jinguang	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	“Ли Жин Жи” ХХК-ийн эмнэлэг	ГЭ0001854	Уламжлалт анагаах ухаан судлал	Эмчлэх	1 жил